

ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ  
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /мянган төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
<b>Нэг. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:</b>							
<b>1.1 Стратеги төлөвлөгөөний зорилго 1: “Бодлогын баримт бичгүүд болон хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох” “бүсийн дэд бүтэц, хөгжлийн бодлого гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</b>							
1.1.1	“Цагааннуур” чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн, Засгийн газраар батлуулах Барилга, хот байгуулалтын яамны ажлын хэсэгтэй хамтран ажиллах.	250 сая төгрөг / улсын төсөв/	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан эсэх /90 хувь/	-“Инженер геодези” ХХК нь 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамтай байгуулсан 2022/238 дугаартай Цагааннуур чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах гэрээт ажлыг гүйцэтгэж байна.	Бүсийн Хөгжлийн ерөнхий чиглэлийг тодорхойлох, байгууллагын алсын хараа, зорилго, зорилт, хүрэх үр дүнг тодорхойлж ажлын даалгаврын төсөлд тусгах санал тодорхой болсон байна.	-Цагааннуур чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын дагуу хот төлөвлөлтийн суурь судалгаа, байр зүйн зураглал, инженер-геологийн судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг боловсруулж дууссан. Төлөвлөлтийн үндсэн шийдлийг боловсруулсан. Үндсэн шийдлийн дагуу инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлтүүд боловсруулагдсан. -Зам тээврийн хөгжлийн яам, орон нутгийн холбогдох байгууллагуудаас бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд шаардлагатай дэд бүтцийн хангамжийн /Зам, цахилгаан/ нөөц, судалгаа, мэдээллийг тухай бүрд авч “Инженер геодези” ХХК-д хүргүүлж ажиллав.	90%

					<p>-Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг эрчимжүүлэхээр Барилга, хот байгуулалтын яам, Эдийн засаг, хөгжлийн яам, “Инженер геодези” ХХК-ийн төлөөлөл 6 удаагийн уулзалт, хурлыг 2023 онд зохион байгуулсан.</p> <p>-Гүйцэтгэгч компаниас Монголын архитекторуудын эвлэлийн 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн.</p> <p>-Бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцүүлсэн.</p> <p>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд магадлал хийлгэх хүсэлтийг гүйцэтгэгч байгууллагаас БХБЯ-нд хүргүүлсэн.</p> <p>-Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалын хавсралтаар баталсан Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах 250 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах ажлын даалгаврыг боловсруулан Барилга, хот байгуулалтын яамтай зөвшилцөж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр</p>
--	--	--	--	--	--

					<p>хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас тендер сонгон шалгаруулалт зарлаж, 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр нээсэн бөгөөд гүйцэтгэгчээр "Хайдродизайн прожект" ХХК шалгарсан .</p> <p>-Эдийн засаг, хөгжлийн яамнаас Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Хайдродизайн прожект" ХХК-тай байгуулж, дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <p>-Чөлөөт бүсийн талбайд очиж инженерийн суурь судалгааг хийсэн. Урьдчилсан трассын схем, барилга, байгууламжийн байршлыг боловсруулж зөвшилцөх ажил хийгдсэн.</p> <p>-Инженер геодезийн судалгаа хийж зураглал гүйцэтгэх ажил, Инженер геологийн хайгуулын судалгаа, дүгнэлт боловсруулах ажил хийгдсэн. Эхлэлийн тайланг загвар зураг баталгаажуулалтын хамт ирүүлснээр ажлын гүйцэтгэл 30%-тай байна.</p> <p>-Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах эхний болон дунд шатны барилгажилтад шаардагдах 6.3 МВт хүртэлх хүчин чадлын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг судлуулахаар Эрчим хүчний яаманд албан хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлсэн.</p> <p>Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын даргын албан</p>
--	--	--	--	--	--

						<p>үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анартай бүсийн Захирагчийн ажлын албаны дарга Ц.Итгэл, дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн дарга Б.Ардабек нар уулзаж бүсийн өнөөгийн байдал, 2024 онд хэрэгжүүлэх дэд бүтцийн ажлуудын талаар танилцуулж цаашид Ази-Европыг холбосон олон улсын АН-4 авто замыг Цагааннуур чөлөөт бүсийн орцтой холбож тээвэр логистикийн төв байгуулах боломжийн талаар санал солилцсон. -Бүсийн олон нийтэд үйлчлэх барилгын (Чөлөөт бүсийн болон мэргэжлийн албадын албан контор, лаборатори) инженер геологийн судалгааны үнэ, зураг төслийн үнийг Монгол Улсын тэргүүлэх төсөвчнөөр хийлгэсэн.</p>	
1.1.2	<p>Батлагдсан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тус бүсийн орц гарцыг шинээр төлөвлөх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.</p>	<p>Үйл ажиллагаа</p>	<p>1 төлөвлөгөө</p>	-	<p>Батлагдсан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тус төлөвлөгөөнд тусгагдсан ажил хийгдсэн байна.</p>	<p>Бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан Өлгий-Улаанбайшинт чиглэлийн олон улсын чанартай авто замын 66, 69 дэх километр хэсэгт орц гарц гаргахаар зам хариуцагч “Жол” ХХК, Цагааннуур тосгоны Захирагчийн ажлын албанаас санал авч, аймгийн Мэргэжлийн хяналтын газраар дүгнэлт гаргуулж, холбогдох баримт бичгийн хамт Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж, тус яамны 2023 оны 05-ны өдрийн 23-ны өдрийн 06/2423 дугаар албан бичгээр зөвшилцсөн болно. Хот байгуулалтын бэлтгэл арга хэмжээ, зам, замын байгууламжийн зураг хийх шатанд гүйцэтгэх боломжтойгоор тайлан, төсөл арга хэмжээнд тусгасан.</p>	100%

1.1.3	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia-ийн цахим үйлчилгээг бүсэд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд бүртгүүлэх, бүртгэлийн гэрчилгээ авах үйлчил -гээг цахим хэлбэрт шилжүүлэх	-	E-Mongolia системээр тус үйлчилгээг үзүүлснээр цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжиж, хөрөнгө оруулагч ААН, иргэд үйл ажиллагаагаа явуулахад төрийн үйлчилгээг илүү хялбар, нээлттэй, ил тод, хүртээмжтэй болно.	-“Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх тусгай журам”-ийн дагуу чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэж, Чөлөөт бүсийн гэрчилгээ олгох, бүртгэхээс татгалзах, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах үйл ажиллагааг цахимжуулах чөлөөт бүсэд бүртгэх бүртгэлийн үйлчилгээг e-business цахим порталаар дамжуулан нэг цонхны үйлчилгээгээр үзүүлэх арга хэмжээ авах хүсэлтээ 2023.10.09-ний өдрийн №116 тоот албан бичгээр Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга Х.Ардаханд хүргүүлсэн. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгогч “Тридум Кей” компанид хандаж байгууллагын тоон гарын үсэг авсан. Ингэснээр байгууллагын үйл ажиллагаа хэвийн, шуурхай явагдах тухайлбал онлайн орчинд гэрээ байгуулах, төрийн үйлчилгээг цахимаар авах боломжтой болж байна.	80%
1.1.4	Цагааннуур тосгоноос чөлөөт бүс хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах талаар Цахим хөгжил харилцаа холбооны яамтай хамтран ажиллах.	Үйл ажиллагаа	Ажлын явц сайжирсан эсэх.	-	Шилэн кабелийн сүлжээнд холбогдсон байна.	-Одоогийн нэг цэгийн үйлчилгээний барилгад шилэн кабелийн сүлжээ байгуулахад 41.8 сая төгрөгийн төсөв шаардагдах тооцоо гарсан. Төсвийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2 удаа албан бичгээр хандсан. Тус яамнаас “Инженер геофизи” ХХК-ны боловсруулж буй Ерөнхий төлөвлөгөөгөөр чөлөөт бүсийн	70%

						<p>захиргааны байрны байршил цаашид өөрчлөгдөх учраас үр ашиггүй зардал гарах учир боловсруулагдаж байгаа Ерөнхий төлөвлөгөөтэй нийцүүлж 2024 онд шинэ байршилд харилцаа холбооны сүлжээний хөрөнгө оруулах талаар санал ирүүлсэн. 2024 оны улсын төсөвт шинэ байршилд баригдах харилцаа холбооны сүлжээний эхний ээлжийн барилга, байгууламжийн ажилд /Холбоо мэдээллийн сүлжээний барилга, Гол шилэн кабель 48 кор, FO-48, 8760метр, (4+0) худаг сувагчлал 8440м/ 2.9 тэрбум төгрөгийн санал өгсөн.</p> <p>-Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах барилга, байгууламжид шаардагдах харилцаа холбооны техникийн нөхцлийг “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-иар судлуулан шийдвэрлэлүүлсэн.</p>	
1.1.5	Цагааннуур чөлөөт бүсэд тээвэр логистикийн төв, транзит тээврийг хөгжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах.	Үйл ажиллагаа	Тээвэр логистикийн төв, транзит тээврийг хөгжүүлэх эхлэл тавигдсан	Тус бүсэд тээвэр, логистикийн төв байгуулах боломжийн талаарх судалгааг Зам, тээврийн хөгжлийн яамтай хамтран хийх саналыг 2022.02.11-ний өдрийн №21 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэв. Үүний хүрээнд: Логистикийн төв, ачаа терминалын ТЭЗҮ, зураг төслийн ажлын даалгаврын төслийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэв.	Монгол Улсын баруун бүсийн босоо тэнхлэг олон улсын АН-4 чиглэлийн авто замын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр хөрш орнуудтай хамтарч тээвэр логистикийн төв, транзит тээврийг хөгжүүлэх	<p>-Цагааннуур чөлөөт бүсэд тээвэр, логистикийн төв байгуулах талаарх саналыг Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсаны дагуу бэлтгэл ажлын хүрээнд бүсийн 1 га талбайд хийгдэх бетонон талбайн ажлын төсвийг мэргэжлийн төсөвчнөөр хийлгэсэн.</p> <p>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 22.2 га газарт барилгажилтын төсөл, инженер геологийн судалгаа, тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах хүсэлтээ Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэнээр Барилга, хот байгуулалтын сайдын “Барилгын дүрэм шинэчлэн батлах тухай” 2020 оны 108 дугаар</p>	70%

						<p>тушаалаар баталсан “Зураг төслийн ажлын жишиг үнэ (БД 81-16-20)”ийн дагуу Тээвэр логистикийн төвийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах үнийг тооцож ирүүлсэн.</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөлд Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын хүрээнд Цагааннуур чөлөөт бүсээс тусгах саналаа боловсруулж хүргүүлсэн. Худалдаа тээвэр, логистик, гаалийн хяналтын талбай барьж байгуулах төсөл арга хэмжээний санал дээрх төлөвлөгөөний төсөлд багтсан.</p> <p>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 замыг түшиглэн 90 га талбайд тээвэр, логистикийн төв байгуулахаар төлөвлөсөн бөгөөд тус төвийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хөрөнгө оруулалтын тооцоог холбогдох жишиг үнийн дагуу Зам тээврийн хөгжлийн яамнаас тооцож ирүүлсэн.</p>	
<b>Хоёр: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ:</b>							
1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт-2.1 “Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээллэл сурталчилгааг өргөжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ</b>							
2.1.1	Чөлөөт бүсэд төрийн үйлчилгээ үзүүлэх Гааль, дотоодын цэрэг зэрэг төр захиргааны байгууллагуудтай хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажиллах.	Үйл ажиллагаа	Чөлөөт бүсэд ажиллах төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах	2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын Дотоодын цэргийн 829-р гэрээт тусгай салбартай Хамгаалалтын гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Төрийн үйлчилгээ үзүүлэх үзүүлэх мэргэжлийн албадын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажил хангагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 412 дугаар тогтоолоор Цагааннуур чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлж үйл ажиллагааг нь эхлүүлсэнтэй холбоотойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: -Баян-Өлгий аймгийн удирдлагууд, Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар, Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар, Баян-Өлгий	100%

			<p>-Чөлөөт бүсийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Шадар сайдын Ажлын алба, БНТУ-ын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллахад хамтран ажиллах тухай саналыг албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд 2022.03.18-ны өдрийн №29 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.</p>	<p>аймгийн Онцгой байдлын газар, Баян-Өлгий аймгийн Авто тээврийн төв зэрэг төрийн үйлчилгээг бүсэд хэрэгжүүлэх байгууллагуудын төлөөллүүдийн хамт 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Цагааннуур чөлөөт бүсэд газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцаж ажиллах явцдаа дараах асуудлуудыг чөлөөт бүсийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах ажлын хүрээнд шийдвэрлэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1.Чөлөөт бүсийн гаалийн хяналтыг хэрэгжүүлэх талбайн хяналтын камеруудыг иж бүрэн шинэчилсэн,</li> <li>2.Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд үйл ажиллагаа явуулах 2 албан өрөөг аймгийн төв Өлгий суманд гаргаж өгсөн,</li> <li>3.Аймгийн Засаг даргын Тамгын газраас Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албатай хамтран 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр орон нутгийн бизнес эрхлэгчидтэй Цагааннуур чөлөөт бүсийг нээж байгаатай холбогдуулан бизнес уулзалт зохион байгуулсан.</li> </ol> <p>-2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын гишүүн Т.Аубакир, аймгийн Засаг дарга Х.Арман, болон орон нутгийн төлөөлөл Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан. Бүсийн үйл ажиллагаа байнгын ажиллагаанд шилжсэнтэй холбоотой УИХ-ын гишүүн Т.Аубакир бүсийн Захирагч Б.Нурбект цаашид хэрэгжүүлэн ажиллах хэд хэдэн үүрэг даалгавар болон чиглэл өгсөн.</p>
--	--	--	---	--



					<p>-2023 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд бүсийн нээлтийн ажиллагаа болон Олон улсын үзэсгэлэн худалдааг Цагааннуур чөлөөт бүсэд зохион байгуулсан.</p> <p>-Нээлтийн үйл ажиллагаанд нийтдээ гадаад дотоодын 100 гаруй аж ахуйн нэгж, иргэд оролцож худалдаа, үйлчилгээ үзүүлсэн. Нээлтийн үйл ажиллагаанд Монгол Улсыг төлөөлж:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ УИХ-ын гишүүн Б.Бейсен</li> <li>✓ Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга Ш.Хавыл</li> <li>✓ Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Камалият</li> <li>✓ Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын дарга Х.Эрдэнэбулган</li> <li>✓ Баян-Өлгий аймгийн Засаг даргын орлогч Х.Арман</li> <li>✓ Баян-Өлгий аймгийн Тамгын газрын дарга Б.Мухамед</li> <li>✓ Ногооннуур сумын Засаг дарга Б.Есболат</li> <li>✓ Цагааннуур тосгоны Захирагч А.Арыстан болон төрийн бүх шатны байгууллагын дарга төлөөлөгч нар оролцсон.</li> </ul> <p>ОХУ-ыг төлөөлж:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Махалов Виталий Борисович /Бүгд Найрамдах Алтай Улсын Засгийн газрын орлогч дарга, төлөөлөгчдийн тэргүүн/</li> <li>✓ Терехин В.Ю. /Бүгд Найрамдах Алтай Улсын тэргүүний туслах/</li> <li>✓ Архипов А.Н. /Бүгд Найрамдах Алтай улсын Худалдаа, аж үйлдвэрийн</li> </ul>
--	--	--	--	--	---

						<p>танхимын дарга, бизнес зохион байгуулагч/</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Логинова Т.В. /Бүгд Найрамдах Алтай улсын Экспортыг дэмжих төвийн захирал/</li> <li>✓ Коробейникова Н.В. /Бүгд Найрамдах Алтай улсын Экспортыг дэмжих төвийн орлогч дарга/</li> <li>✓ Жуков А.А. /Бүгд Найрамдах Алтай улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын Нийгмийн бодлогын хорооны дарга/</li> <li>✓ Ивашкин А.С. /Бүгд Найрамдах Алтай улсын Ахмадын зөвлөлийн дарга/ болон УК Аж үйлдвэрийн парк, Тусгай материал ХХК, Биотех ХХК, Уулын эмийн сан, Кайрал ХХК, Оазис ХХК, МедАлт ХХК, АлитайПант ХХК-ний ерөнхий захирууд оролцсон.</li> </ul> <p>БНХАУ-ыг төлөөлж:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Алтайн бүсийн худалдааны товчооны Дэд захирал Фү Яо</li> <li>✓ Алтайн бүсийн худалдааны товчооны оффисын захирал Шао Цян,</li> <li>✓ Altay Siyuantong International Trade ХХК-ний Ерөнхий менежер, Борлуулалтын менежер,</li> <li>✓ Чинхэ мужийн Чиннэн импорт экспортын худалдааны ХХК-ний Ерөнхий захирал</li> <li>✓ Фухай Бэйгэ нэхмэл, оёдлын үйлдвэрлэлийн ХХК-ний Ерөнхий захирал</li> </ul>
--	--	--	--	--	--	--

					<p>✓ Fuhai Baige Construction Technology Co ХХК-ний Ерөнхий зохион байгуулагч</p> <p>✓ Жимунай дүүргийн Жиахен өнгөт хэвлэл, сав баглаа боодлын ХХК-ний Ерөнхий захирал болон төлөөллүүд оролцсон.</p> <p>-Бүсийн Захирагч Б.Нурбек, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга И.Хайратбек, Дотоодын цэргийн Штабын орлогч, Харуул, хамгаалалтын хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Мөнх-Итгэл, Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын дарга дэд хурандаа Ө.Танат нар бүсийн зүгээс хийж хэрэгжүүлж байгаа ажлууд, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, харуул хамгаалалтыг гүйцэтгэхэд дотоодын цэрэгтэй хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлсон.</p> <p>-Бүсэд төрийн үйлчилгээ үзүүлэх гааль, мэргэжлийн хяналт, дотоодын цэрэг зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Үүнд:</p> <p>-Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын Дотоодын цэргийн 829-р гэрээт тусгай салбартай “Хамгаалалтын гэрээ”-г байгуулан гэрээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>- Дотоодын цэргийн 829-р гэрээт тусгай салбарын 2023.08.02-ны өдрийн №30/4949, 2023.08.23-ны өдрийн №30/5357, албан бичгүүдээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Цагааннуур чөлөөт бүсийн объектын дотоод орчны судалгаа болон хөрөнгө оруулалттай холбоотой</p>
--	--	--	--	--	--

						ирүүлсэн хүсэлтийг Эдийн засаг, хөгжлийн яаманд тухай бүрд уламжилсан.	
2.1.2	Гадаад, дотоодын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж, туршлага судлах, үр дүнд хүрсэн ажил, үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	Үйл ажиллагаа	Туршлага судлагдсан байдал /2 удаа/	БНХАУ, ОХУ, БНТУ, БНКаЗУ-ын чөлөөт бүсүүд болон дэлхийн бусад чөлөөт бүсүүдийн талаар судалгаа хийгдсэн. Дэлхийн чөлөөт бүсүүдийн холбоонд элсэн орсон. Бүсийн талаарх танилцуулгыг бэлтгэн ДЧБХ-нд цахим шуудангаар хүргүүлж, 2022.02.07, 2022.02.08, 2022.02.18, 2022.02.28, 2022.03.24-ний өдрүүдэд харилцан мэдээлэл солилцож тус байгууллагын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд хамтран ажилласан.	Стратегийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах гадаад, дотоодын байгууллагуудыг судлах, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг зохион байгуулах;	-БНХАУ-ын ШУӨЗО-ны Алтай хотын гадаад харилцааны хөрөнгө оруулалтын орлогч дарга Дүйсений Еркин, МҮХАҮТ-ын Баян-Өлгий аймгийн салбарын тэргүүн Муратай нар Цагааннуур чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, цаашид чөлөөт бүсэд ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж болох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг бүсийн үйл ажиллагаанд хэрхэн татаж оруулах талаар харилцан санал солилцсон. -Монгол-Оросын бизнесийн зөвлөлийн зүгээс 2023 оны 03 дугаар сарын 13-16-ны өдрүүдэд зохион байгуулсан ОХУ-ын Алтайн хязгаарын бүс нутгийн бизнес уулзалтад бүсийн удирдлага, албан хаагчид оролцож чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг дээрх бүс нутгийн ажил хэрэгч хүмүүст сурталчлан ажилласан. -БНХАУ-ын чөлөөт бүсүүд болон ОХУ-ын чөлөөт бүсүүдийн туршлагыг судлаж, судалгааг шинэчилсэн. -ОХУ, БНХАУ, БНТУ, БНКаЗУ, АНУ-ын чөлөөт бүсүүд, дэлхийн тэргүүлэгч чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий аргачлалын судалгаа, чөлөөт бүсээ хөгжүүлэх аргачлал ба цаашдаа хамтран ажиллах чиглэлийн судалгаанууд хийгдсэн.	100%

						-Цагааннуур чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах сонирхолтой ОХУ-ын “Наша мама” компанийн захирал Игорьтой онлайнаар холбогдож бүсийн талаарх мэдээлэл болон Чөлөөт бүсийн тухай хуулийг орос хэл дээр бэлтгэн цахим шуудангаар илгээсэн.	
2.1.3	Бүсийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах Хөнгөлөлт, хөрөнгө оруулалтын таатай орчин, бүсийн өнөө, хэтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг веб сайт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих	Үйл ажиллагаа	Байгууллагын цахим хуудас болон албан ёсны цахим сүлжээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой болон хууль зүйн холбогдолтой цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг тухай бүр нийтэлж ажиллах	<a href="http://tsagaannuur.freezone.gov.mn/">http://tsagaannuur.freezone.gov.mn/</a> , <a href="https://www.facebook.com/CholootBus/">https://www.facebook.com/CholootBus/</a>	Хөрөнгө оруулалтыг татах зорилгоор гадаад, дотоодын компаниудтай уулзалтуудыг зохион байгуулж Чөлөөт бүсийг сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлэх. -Төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдэж, хамтын ажиллагааны түншлэл буй болсон байх	-Гадаад, дотоодын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд Цагааннуур чөлөөт бүсийг сурталчлан таниулах, тэдэнтэй холбоо тогтоох зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдсан бизнес уулзалт, форум, экспо арга хэмжээнүүдэд тогтмол оролцов. -Аймгийн “Дербес” телевиз болон орон нутгийн радиод чөлөөт бүсийн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаар бүсийн Захирагч дэлгэрэнгүй ярилцлага тогтмол өгч ажилласан. -Хэвлэл мэдээлэл: Бүсийн <a href="http://tsagaannuur.freezone.gov.mn/">http://tsagaannuur.freezone.gov.mn/</a> , <a href="https://www.facebook.com/CholootBus/">https://www.facebook.com/CholootBus/</a> цахим хуудсыг идэвхижүүлж цаг үеийн мэдээ мэдээлэл, зурган постеруудийг цаг тухай бүрд бэлтгэн оруулж байна. -Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 2023 оны 11-р сарын 23-24-ний өдрүүдэд “Нээлттэй Баян-Өлгий” эдийн засгийн чуулга уулзалт Өлгий хотноо зохион байгуулагдаж тус бүсийн Захирагч хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон цаашдын үйл ажиллагааны талаар илтгэл тавьж панел хэлэлцүүлэгт оролцож иргэдийн сонирхсон асуултанд	100%

						хариулт өгч ажиллав. Бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалт, хууль эрх зүйн орчин, татварын хөнгөлөлттэй нөхцөл, давуу талын мэдээллийг багтаасан танилцуулга, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө ба BROCHURE зэрэг бичиг баримтуудыг Орос- Монгол, Монгол-Орос, Монгол- Казах хэл руу хөрвүүлэн бэлтгэж оролцсон. Чуулга уулзалтын хүрээнд “Ханшиншие ХХК” –тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.	
2.1.4	Хоргос эдийн засгийн чөлөөт бүс-хуурай боомттой байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаа	Санамж бичиг	Бүгд Найрамдах Казахстан Улсын хил орчмын хамтын ажиллагааны “Хоргос” бүстэй хамтран ажиллах санамж бичиг байгуулагдсан.	Бодлогын хэрэгжилт хангагдаж, байгууллагын үйл ажиллагаа эрчимжсэн байна.	Казахстан Улсын элчин сайдтай бүсийн Захирагч, ажлын албаны дарга, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтсийн дарга болон хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нар уулзалт зохион байгуулж, Хоргос эдийн засгийн чөлөөт бүстэй байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хоргос-зүүн хаалга” эдийн засгийн тусгай бүстэй хамтран хуурай боомтыг хөгжүүлэх чиглэлд Цагааннуур чөлөөт бүсэд тээвэр логистикийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд талууд ахиц гаргах, эрчимжүүлэхээр зөвшилцсөн.	100%
2.1.5	Шадар сайдын ажлын алба, БНТУ-ын Худалдааны яам хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагаа	Санамж бичиг	“Чөлөөт бүсийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Шадар сайдын ажлын алба болон Бүгд Найрамдах Турк Улсын Худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т Монгол Улсаас Бүгд Найрамдах Турк	Бодлогын хэрэгжилт хангагдаж, байгууллагын үйл ажиллагаа эрчимжсэн байна.	Шадар сайдын ажлын алба, БНТУ-ын Худалдааны яам хооронд байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.  Бүгд Найрамдах Турк Улсын хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг (ТИКА)-ийн Улаанбаатар дахь суурин төлөөлөгч Эмрах Устөмер Цагааннуур чөлөөт бүсийн Захирагч, албан хаагчдыг хүлээн авч уулзав.	100%

				Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхэт Элчин сайд Р.Болд (Монгол Улсын Шадар Сайдын Ажлын албыг төлөөлж), Бүгд Найрамдах Турк Улсын Худалдааны яамыг төлөөлж Бүгд Найрамдах Турк Улсын Гадаад Худалдааны Дэд сайд нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсон.		Бүсийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар дэлгэрэнгүй танилцуулга хийж хоёр байгууллагын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон.  Уулзалтын төгсгөлд бүсийн Захирагч байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад одоогийн ашиглаж байгаа техник тоног төхөөрөмжүүд нь шаардлага хангахгүй, шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт тавьсан.	
2.1.6	Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, бүсэд үйл ажиллагааг нь эхлүүлэх.	Үйл ажиллагаа	Хөрөнгө оруулалтын гэрээ	Хөрөнгө оруулалтын гэрээний загвар боловсруулагдаж бэлэн болсон.	Хөрөнгө оруулалтын гэрээ, түүнтэй холбогдох баримт бичгүүдийг хууль эрх зүй, холбогдох дүрэм, журмын хүрээнд боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулснаар аж ахуйн нэгжүүдэд чөлөөт бүсэд үйл ажиллагаагаа өөрсдийн боломжид тулгуурлан эхлүүлэх нөхцөл боломж бүрдсэн байна. Хөрөнгө оруулагчидтай хамтран чөлөөт бүсэд баригдах барилга байгууламжийн нэгдсэн нэг ойлголттой (дизайн, талбайн хэмжээ ... г.м) болсон байна	- Бүсэд үйл ажиллагаа эрхлэхээр 54 аж ауйн нэгж бүртгүүлж цэвэрлэгээ, тохижилтын гэрээ болон худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх гэрээг бүсийн Захирагчийн ажлын албатай байгуулсан.Эдгээрээс 5 аж ахуйн нэгж эхний ээлжинд бараа бүтээгдэхүүнээ татан байршуулахад ашиглах 5 чингэлэгийг баталсан төлөвлөлт, зургийн дагуу байршуулсан, нэг аж ахуйн нэгж агуулах барьсан.	80%
<b>Зорилт-2.2. Чөлөөт бүсийн дэд бүтэц, бүсэд газар ашиглах зөвшөөрөл олгох</b>							
2.2.1	Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд нэгж талбарын цахим хувийн хэргийг холбогдох	Үйл ажиллагаа	Бүртгэгдсэн хуулийн этгээдийн тоо	Цагааннуур чөлөөт бүсэд 4 аж ахуй нэгжид газар эзэмшүүлсэн. Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн системд чөлөөт бүсэд	Төрөөс хот байгуулалтын асуудлаар баримталж буй бодлоготой чөлөөт бүсийн хот	Газрын улсын бүртгэл, баталгаажилт хийлгэж 4 хуулийн этгээдийн газрын кадастрын мэдээллийг мэдээллийн санд оруулж, цаасан болон цахим хувийн хэргийн бүрдлийг хангаж,	100%

	журмын дагуу бүртгэж, оруулах			олгогдсон газрын мэдээллийг оруулж нэгж талбарын архив үүсгэсэн.	байгуулалтын асуудал уялдана	холбогдох журмын дагуу бүртгэлд оруулсан.	
2.2.2	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэж Засгийн газраар батлагдсаны дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж батлах.	Үйл ажиллагаа	Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо	13 аж ахуй нэгжийг бүртгэж бүртгэлийн гэрчилгээ олгосон.	Аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, бүртгэх, хувийн хэрэг хөтлөх.	Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө шинэчлэн боловсруулагдаж байна. Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлийн хурлаар 2022.12.8-ны өдөр хэлэлцэгдэнэ дэмжигдсэн. БХБЯ-нд магадлал хийлгэхээр боловсруулж байгаа компианаас хүсэлт хүргүүлсэн. Магадлалын нэгдсэн дүгнэлт гарсанаар Засгийн Газрын хуралдаанаар батлагдана. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан Цагааннуур чөлөөт бүсийн газрын төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт гаргаж өгсөн. Хот байгуулалтын тухай хуулинд зааснаар ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тус бүсэд газар олголтыг бүсийн Захирагчийн мэдэгдлээр түр зогсоосон. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар ХЕТ-тэй уялдуулан тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах юм.	
2.2.3	Газар эзэмших, ашиглахтай холбоотой өргөдөл, хүсэлтийг хүлээн авч газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулах зарчмаар	Үйл ажиллагаа	Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн тоо	Цагааннуур чөлөөт бүсэд 4 аж ахуй нэгжид газар эзэмшүүлсэн.	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн төсөл, бизнес төлөвлөгөөтэй танилцаж дүгнэлт гаргасны үндсэн дээр газар олголтын асуудал хууль журамд нийцүүлэн шийдвэрлэх.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.7.14.3 дах хэсэгт заасны дагуу Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн	100%



	газар олгох ажлыг зохион байгуулах					боловсруулагдаж байна. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаатай холбогдуулан Хот байгуулалтын хуулинд зааснаар ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу тус бүсэд газар олголтыг түр зогсоосон. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Засгийн газрын хуралдаанаар батлагдсаны дараа уг төлөвлөгөөний дагуу тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, төсөл сонгон шалгаруулалт болон дуудлага худалдаа зохион байгуулах ажил үргэлжлэн хийгдэнэ.	
2.2.4	Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдэд хяналт тавьж, тооллого явуулна	Үйл ажиллагаа	Хууль, дүрмийн шаардлага хангасан байх	-	Төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлж. Тайланг танилцуулах	Нутаг дэвсгэртээ хамаарах геодезийн цэг, тэмдэгтүүдэд хяналт тавьж, тооллого явуулсан.	100%
2.2.5	Газар эзэмших, ашиглах эрхийн зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээ	Холбогдох хууль, дүрмийн дагуу	-	Хүсэлт ирүүлсэн тухай бүр	“Мега Прожект инвентмент чөлөөт бүс” ХХК-д газар эзэмшүүлэх үед Улсын бүртгэлийн ерөнхий газар, Алтанбулаг чөлөөт бүс, Замын-Үүд чөлөөт бүс, Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн хамтарсан 1436,А\72, А\56,33 дугаар бүхий хамтарсан тушаал, захирамжийг дагаж мөрдөх болсонтой холбоотой газар эзэмшигчийн оноосон нэрийг зарим бичиг баримтад өөр, өөрөөр бичиж, бичвэрийн болон процессын алдаа гарсныг залруулж, газар эзэмшигчийн оноосон нэрийг нэг болгон өөрчилж Захирагчийн 2023 оны А24 дугаар захирамж гарсан.	100%
2.2.6	Газрын зөрчил, маргаантай холбоотой нотлох баримт, лавлагаа, мэдээллийг	Үйл ажиллагаа	Зөрчилтэй нэгж талбаруудын Холбогдох	Зөрчилгүй	Зөрчилтэй нэгж талбаруудын зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах	Газрын аливаа зөрчил, маргаан гараагүй.	100%

	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гаргаж өгөх		хууль, дүрмийн дагуу				
2.2.7	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь заалтын дагуу шаардлагатай газар эзэмшигч, ашиглагчдад газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт гаргуулах мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Үйл ажиллагаа	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь газрын талаарх шаардлага хангасан нотлох баримт, мэдээллээр хангагдсан байна	Хүсэлт ирүүлсэн тухай бүр	Хүсэлт ирүүлсэн тухай бүр	Чөлөөт бүсэд газар эзэмшиж буй 4 аж ахуй нэгжид газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт гаргуулах мэдэгдэл хүргүүлсэн.	80%
2.2.8	Бүсэд бүртгэлтэй хашаа, барилга байгууламжийн төлөв байдлыг үнэлэх, бат бөх чанарыг тооцоолох, барилга ашиглалтын найдвартай байдал, норм дүрмийн шаардлагыг хангуулах, бүрэн бүтэн байдалд хяналт тавих, авто тээвэр, техникийн хэрэгслийн урсгал засвар, үйлчилгээ хийлгүүлэх	Үйл ажиллагаа	Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгаа/1ш/ Урсгал засвар, үйлчилгээ	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг Тооллогод хамрагдаж үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн.	-Барилга ашиглалтын найдвартай байдлын норм дүрэм хангагдсан байна. -Дэд бүтцийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийн ажлуудын засвар үйлчилгээг өөрсдийн боломжоор хийж гүйцэтгэх.	-Тус чөлөөт бүсэд байрлах улсын онц чухал объектын харуулын байр, хашаа, бусад барилга, байгууламжийн чанар, насжилт, ашиглалтын төлөв байдалд иж бүрэн дүгнэлт гаргуулахаар Баян-Өлгий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт албан бичгээр хандсан боловч Зөвлөх үйлчилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулах талаар зөвлөмж ирүүлсэн.  -“Алтай шар говь” ХХК болон Цагааннуур чөлөөт бүстэй 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн ЦЧБ07/23-05 дугаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд Цагааннуур тосгон дахь Цагааннуур чөлөөт бүсийн Нэг цэгийн үйлчилгээний барилга болон төв хаалга, ариун цэврийн цэгийн засвар үйлчилгээг гүйцэтгүүлэв.  -Цагааннуур чөлөөт бүсэд гаалийн хяналтыг нэвтрүүлэхэд тавигдах	100%

					<p>шаардлагын дагуу тус байгууллагад ашиглагдаж байгаа мэдээллийн систем, технологи, тоног төхөөрөмжийн (хяналтын камер) хүчин чадлын судалгаа хийгдсэн.</p> <p>-Эхний ээлжийн дулаан, цахилгаан, усан хангамж, ариутгах татуурга, харилцаа холбооны барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын зардлыг урьдчилсан байдлаар тооцож, 2024 оны төсөвт 12 тэрбум төгрөгийн санал өгсөн.</p> <p>-Мөн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх эхний ээлжийн барилгажилт, бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх, эрчимжүүлэхээр эхний ээлжийн барилга, байгууламжийн /1МВт/ цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газраас авсан. Эхний болон дунд шатны барилгажилтын цахилгаан хангамжийн хүчин чадал 7.6 МВт байхаар тооцоо гарсан бөгөөд Баруун бүсийн Эрчим хүчний систем ТӨХК-ны өгсөн мэдээллээр Цагааннуур тосгоны 35/10кВ-ийн одоо байгаа дэд өртөөний трансформаторын хүчин чадлыг 6.3 МВт хүртэл нэмэгдүүлэх боломжтой талаар урьдчилсан мэдээлэл өгсөн.</p> <p>-Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдах эхний болон дунд шатны барилгажилтад шаардагдах 6.3 МВт хүртэлх хүчин чадлын цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг судлуулахаар Эрчим</p>
--	--	--	--	--	---

						хүчний яаманд албан хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлсэн.	
Зорилт- 2.3. Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах, Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох							
2.3.1	Чөлөөт бүсэд хөрөнгө оруулах хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэх, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, хувийн хэрэг нээж хөтлөх.	Үйл ажиллагаа	Бүртгэлийн гэрчилгээ	Цагааннуур чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй 13 аж ахуйн нэгжийг бүртгэж бүртгэлийн гэрчилгээ олгов.	Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдаж бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдсэн байна.	Одоогийн байдлаар бүсэд 65 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлсэн.	100%
2.3.2	Чөлөөт бүсэд архи согтууруулах ундаа, тамхи худалдаалах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжид согтууруулах ундаа, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу, ЭЗХЯ-аас баримталж буй бодлоготой уялдуулан тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэх.	Үйл ажиллагаа	Хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжид журмын дагуу тусгай зөвшөөрөл олгох.	Жилийн эцсийн байдлаар хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байхгүй байна.	“Зөвшөөрлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулга 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан “Чөлөөт бүсэд мөрдөх журам”, “Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам”, “Чөлөөт бүсэд тамхи худалдаалах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах ажил Эдийн засаг, хөгжлийн сайдын А/100 тоот тушаалын дагуу хийгдэж байна.	“Чөлөөт бүсэд согтууруулах ундаа, худалдаалах, түүгээр үйлчлэх”, “Тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл”-ийн журмууд эцэслэгдэн батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрийг хүртэл тусгай зөвшөөрөл олгохгүй байхаар Эдийн засаг, хөгжлийн сайдаас бүсийн Захирагчид чиглэл болгосон.	80%
	Чөлөөт бүсээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, Чөлөөт бүсийн тухай хууль, бусад дүрэм журмын хүрээнд үйлчлүүлэх нөхцөл	Үйл ажиллагаа	Хууль эрх зүйн хүрээнд иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг	-	Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр Захирагчийн ажлын албаны ажилтнуудыг хариуцсан чиг үүргийнхэн дагуу хууль, эрх зүйн гарын авлагаар хангаж, сургалт явуулах	-Төрийн байгууллага, хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжүүдийн хамтарсан уулзалт хэлэлцүүлгийг 2023 онд 2 удаа зохион байгуулсан.  -Эхний хэлэлцүүлгийг Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагаа байнгын үйл ажиллагаанд	100%

	бололцоог хангахад анхаарч ажиллах		зөрчигдөөгүй байдал.			шилжсэнтэй холбоотойгоор Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газартай хамтран зохион байгуулсан. Бүсэд үйл ажиллагаа эрхлэхээр бүртгэлийн гэрчилгээ авсан ААН-дэд хилийн чанадаас бараа бүтээгдэхүүнийг оруулж ирэхэд бүрдүүлэх материал, одоогийн мөрдөж байгаа журмуудын талаар мэдээлэл өгсөн. -Удаах хэлэлцүүлгийг Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газар, Дотоодын цэргийн 829-р тусгай салбартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр "Иргэд, аж ахуй, бизнес эрхлэгчдийн уулзалт-2023" зохион байгуулсан. Иргэд, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд бүсэд мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмууд, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар мэдээлэл өгч ажиллав.	
<b>Зорилт-2.4. Иргэн хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээг түргэн шуурхай, ил тод, нээлттэй болгох</b>							
2.4.1	Цагааннуур чөлөөт бүсэд орж, гарч байгаа зорчигч тээврийн хэрэгслийн мэдээг сар, улирал, жилээр гаргаж, мэдээллийн нэгдсэн сүлжээ үүсгэх.	Үйл ажиллагаа	Мэдээ, тайлангийн тоо	-	Бүсэд 2023 онд нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээг тогтмол тоон үзүүлэлтээр гарган ажиллаж байна	-Цагааннуур чөлөөт бүсэд орж, гарч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн мэдээг сар, улирал, жилээр гаргаж, мэдээллийн нэгдсэн сүлжээ үүсгэн ажиллаж байна. Чөлөөт бүсэд тайлант хугацаанд шалган нэвтрүүлэх хаалгаар Байнгын үнэмлэхээр-948, Гаднаас нэвтэрсэн иргэн-472, тээврийн хэрэгсэл-142 шалган нэвтрүүлэн ажилласан.	90%
2.4.2	Цагааннуур чөлөөт бүсийн бараа эргэлтийн мэдээг сар, улирал, жилээр гаргаж, мэдээллийн нэгдсэн сүлжээ үүсгэх.	Үйл ажиллагаа	Мэдээ, тайлангийн тоо	-	2023 оны бараа эргэлтийн мэдээг тогтмол тоон үзүүлэлтээр гарган ажиллаж байна.	VIP Shop нь 6-р сард нээгдэж үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулж байна. Тус дэлгүүрийн хувьд анх нээгдэхэд нийтдээ 2911 ширхэг бараа оруулж ирсэн бөгөөд үүнээс 112 ширхэг бараа борлуулагдсан ба борлуулалт 6.4% -тай байна.	90%

**ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

**Зорилт-3.1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах**

3.1.1	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Тухай бүр	-	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, төрийн албан хаагчийн анкет зэрэглэл, жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна	Засгийн Газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны албан хаагчдын ангилал, зэрэглэлийг болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалинг шинэчлэн тогтоосон. -Албан тушаалын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулах тухай хүсэлтээ Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	100%
3.1.2	Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Сул болон эзгүй орон тоо	Төрийн албаны тухай хуулийн дагуу сул орон тоог нөхсөн.	Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна - Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна	-Төрийн албаны тухай хуулийн 27.2, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3.1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам, загвар батлах тухай” 25 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2-т заасны дагуу Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны мэдээлэл, сонгон шалгаруулалтын захиалгыг Эдийн засаг хөгжлийн яамны салбар зөвлөлд хүргүүлж, сонгон шалгаруулалтыг салбар зөвлөлөөс зохион байгуулж шаардлагатай орон тоог зохих хууль, тогтоомжийн хүрээнд нөхөн бүрдүүлж ажилласан. -Нийт 4 албан хаагчийг байгууллага дотроо сэлгэн ажиллуулж, өөр албан байгууллагаас 1 албан хаагч шилжүүлэн ажиллуулсан.	100%

3.1.3	“Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн систем”-ийн нэгдсэн санг эрхлэх, бүрдүүлэх, хөтлөх, хяналт тавих	Үйл ажиллагаа	Мэдээллийн санд бүртгэгдсэн албан хаагчдын тоо	2022 онд 10 албан хаагчийг шинээр томилсон, өөр албан тушаалд шилжин ажилласан 1, албан тушаалаас чөлөөлөгдсөн 5, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн 1 албан хаагчийн холбогдох мэдээллийг тус тус програмд оруулсан.	-Албан хаагчдын мэдээллийг “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем”-д тухай бүр өөрчлөлт, мэдээллийг оруулсан байна. - Албан хаагчийн цалингийн мэдээллийг тухай бүр оруулсан байна	-Төрийн албан хаагчийн цалингийн системд зохих мэдээллийг шинэчлэн оруулсан. - Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд байгууллагын төрийн албан хаагчдын хөдөлгөөний тайланг шинэчилсэн байдлаар оруулсан. -Цалин хөлстэй холбоотой мэдээллийг тухай бүр шинэчлэн мэдээллийг оруулан ажилласан.	100%
3.1.4	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах		Төлөвлөсөн арга хэмжээний тоо	Хүний нөөцийн хөгжил-нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажилласан. Холбогдох хууль тогтоомжийн дагуу 3 албан хаагчийн цалин, урамшуулал, нэмэгдлийг тухай бүр шинэчлэн тогтоосон.	“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” боловсруулагдсан.	Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн баримт бичиг” тэй уялдуулан тус чөлөөт бүсийн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулсан. - “Авлигаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, мэргэшил мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын төлөвлөгөө” боловсруулагдаж батлагдсан. - Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөөгүй ажилтнуудыг тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагч болгох ажлыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж нэг албан хаагч тангараг өргөсөн. -Албан хаагчдын гаргасан өргөдөл, хүсэлтийг хяналт шалгалт хийж, тулгамдсан асуудлуудыг тухай бүр хууль тогтоомжид нийцүүлэн хариу өгч, Захирагчийн захирамжаар баталгаажуулан шийдвэрлэсэн.	100%

						<p>- Ажилтны ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, хоолны үнийн зохих хувийг холбогдох хууль, журмын дагуу сар бүр олгож байна.</p> <p>Ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>- Албан хаагчдын гэр бүлд хүүхэд мэндэлснийг хүндэтгэл үзүүлж, 10 хоногийн цалинтай чөлөө олгосон.</p>	
3.1.5	Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтворжуулах	Үйл ажиллагаа	Хүний нөөцийн удирдлагад ил тод байдлыг хэрэгжүүлж, ажилтныг ажилд авах, сахилгын шийтгэл ногдуулах, гадаад дотоодын сургалтад оролцуулах үйл ажиллагаа ил тод болох	-Цагааннуур чөлөөт бүсийн 2022 оны 6-р сарын 27-ны өдрийн А/05 дугаар Захирамжаар “Ёс зүйн зөвлөл”-ийг байгуулсан. - Сахилга хариуцлага, дэг журмыг мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгож, зөрчил, дутагдал гаргасан албан хаагчдад зохих арга хэмжээг авч ажиллаж байна. Энэ хугацаанд 4 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.	Албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журам чангарч, хүний нөөцийн удирдлага ил тод болсон байна	-2023 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй байна.  -Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа, чадавхыг сайжруулах зорилготой албан хаагчдыг хамруулсан сургалтыг зохион байгуулж үүрэг хариуцлагыг дээшлүүлэн, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэн ажиллаж байна.	100%
3.1.6	Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийг хангах	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	-	- Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажилласан байна. - Албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийг шинэчлэн	Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд: -Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын шинэчлэн боловсруулж бүсийн Захирагчийн 2023 оны А50 дугаар захирамжаар батлуулсан	100%



					Захирагчаар батлуулсан байна.	-Нийт албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарь батлуулах ажлыг ажилтнуудаас санал авч, Захирагчийн захирамжаар баталгаажуулсан. -Батлагдсан хуваарийн дагуу ажилтанд ээлжийн амралтын мэдэгдэх хуудас олгож, ээлжийн амралтын нөхөн олговрыг олгож ажиллав.	
3.1.7	Захирагчийн ажлын албанд хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтны хөрөнгө ажиллагсдын орлогын мэдүүлгийн хуулийн хугацаанд гаргуулж, тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Үйл ажиллагаа	Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албад хөрөнгө орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтны, хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хугацаанд гаргуулж, тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	Тус Бүсийн 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гарсан албан хаагчдын тайланг хуульд заасан хугацаанд гаргаж Авлигатай тэмцэх газарт албан бичгээр хүргүүлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар шинээр болон шилжин ажилласан 10 албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг системд нээж баталгаажуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Албан тушаалтнуудын 2021 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулж, мэдээ тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.	-Хуулийн хугацаанд Цагааннуур чөлөөт бүсийн 11 албан хаагч Хөрөнгө орлогын мэдүүлгийг байгууллагын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий ажилтанд гаргаж өгөв. Мэдээ тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Цагааннуур чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанд шинээр ажилд орж байгаа албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлгийг гаргуулж албан тушаалд томилогдсон тохиолдолд хуулийн хугацаанд багтаан Хөрөнгө орлогын мэдүүлгийг бөглүүлж ажилласан.	100%
3.1.8	Батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2022 онд албан хаагчдыг Удирдлагын Академиас болон Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан богино болон дунд хугацааны	Ажилтнуудын мэргэжлийн зэрэг ахиулах, давтан сургах, хөрвөх чадвартай болгох, шинээр мэргэшүүлэх сургалтуудыг бүлэглэн багаар зохион байгуулах ажлуудыг төлөвлөн зохион	-Байгууллагын хүний нөөцийг сургах, мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд:  -Сангийн Яамнаас зохион байгуулсан Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн онлайн сургалтад байгууллагын ня-	100%

				<p>сургалтад тогтмол хамруулсан.</p>	<p>байгуулснаар мэдлэг чадвар дээшилж Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангагдана</p>	<p>бо, хүний нөөцийн мэргэжилтэн хамрагдсан.</p> <p>- Төрийн албаны зөвлөлөөс “7:4:10” арга зүйн ээлжит сургалтыг (вэбинар) 7 хоног бүрийн Пүрэв гаригт тогтсон цагт онлайн хэлбэрээр зохион байгуулаж, бүсийн албан хаагчид тогтмол хамрагдсан.</p> <p>-Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино болон дунд хугацааны сургалтад 3 албан хаагч хамрагдсан.</p> <p>-Удирдлагын академиас явуулсан Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг богино хугацааны зайн сургалтад сургалтад 3 албан хаагч хамрагдсан.</p> <p>“Монгол Улсын тээвэр, логистикийн салбар ба хуурай боомт” семинар, хэлэлцүүлэгт Захирагчийн ажлын албаны дарга Ц.Итгэл, дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтсийн дарга Б.Ардабек нар оролцсон.</p> <p>- НҮБ-аас 2023 оны 10 сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг сурталчлан таниулах, төлөвлөгөөг танилцуулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох” цуврал уулзалт хэлэлцүүлэгт бүсийн албан хаагчид хамрагдав.</p> <p>-Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс зохион байгуулсан “Төрийн албан хаагчдад цахим ур чадвар олгох” сургалтанд бүсийн албан хаагчид хамрагдсан.</p>
--	--	--	--	--------------------------------------	--	--

						-Удирдлагын академиас зохион байгуулсан дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад Дэд бүтцийн хөгжил газрын харилцааны хэлтсийн дарга Б.Ардабек хамрагдан дүүргэсэн.	
3.1.9	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагаа	-	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай чөлөөт бүсийн албан хаагчид нэгдэж Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн “Мод үржүүлгийн төв”-ийн талбайд мод тарив. Мод үржүүлэг-агро экологийн сургалтын төвийг Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн найман га талбайд байгуулж Эдийн засаг, хөгжлийн яамны албан хаагчидтай хамтран уг талбайд мод тарих ажилд албан хаагчид идэвхтэй оролцсон.	Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн зорилт, өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэрийн биелэлт хангагдсан байна.	“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам болон Чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албаны албан хаагчид хамт 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Баянгол-Агропарк”-д мод тарин дэмжин оролцлоо. Мөн Цагааннуур чөлөөт бүсийн хашаанд 80 гаруй мод тарьсан.	100%
<b>Зорилт-3.2.Төсөв, санхүү, хяналт-шинжилгээ, дотоод аудит</b>							
3.2.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж санхүүгийн мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд тогтмол хугацаанд байршуулж, олон нийтэд мэдээлэх	Үйл ажиллагаа	2023 оны санхүүгийн мэдээллийг тухай бүр, хугацааны хоцрогдолгү	Шилэн дансны цахим хуудсанд 2022 мэдээ, мэдээллийг хугацаанд нь оруулсан.	Сар бүр Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, санхүүгийн бусад өмч, хөрөнгө, мөнгө	Шилэн дансны хууль батлагдсанаас хойш төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> сайт,	100%

			й байршуулах -2023 оны санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулах		зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тогтмол хугацаанд байршуулж, тайланг олон нийтэд мэдээлсэн байна	мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж, санхүүгийн ил тод байдлын мэдээллийн самбарт 2023 оны төсвийн хуваарь, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах төлөвлөгөө гүйцэтгэл, үйлчилгээний зардал, зэрэг мэдээллийг холбогдох газарт хүргүүлж шилэн дансанд шивж оруулан нийтэд ил тод мэдээлсэн.	
3.2.2	Төсвийн захирагчийн батлагдсан төсвийн хүрээнд тохируулан төсвийн сар, улирлын хуваарь боловсруулах	Улсын төсөв	2023 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан төсвийн хүрээнд тохируулан төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах	Төсвийн захирагчийн 2022 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарийг хуульд нийцүүлэн төсвийг үр ашигтай, хуваарийн дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулсан	Батлагдсан төсвийн санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг шилэн данс болон бусад хэлбэрээр үнэн зөв тайлагнасан байх.  Санхүүгийн тайлан баланс, бусад холбогдох мэдээ, тайлан хуулийн хугацаанд үнэн зөв байна.	-Батлагдсан төсвийн санхүүжилтийн хуваарьт багтаан албан хаагчдын сар бүрийн цалинг тооцон олгож, нийгмийн даатгал, хүн амын орлогын албан татвар, шуудан холбоо, цэвэр бохир ус, байрны түрээс, цахилгаан дулааны төлбөр тооцоог сар бүр холбогдох байгууллагуудын нэхэмжлэхийг үндэслэн тооцоо хийсэн. -Бүсийн 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлан, 2023 оны тодотгосон төсвийн хуваарийг Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн. -Байгууллагын 2024 оны төсвийн төсөөлөл, 2025-2026 оны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн төсөөллийг журмын дагуу боловсруулж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.	100%
3.2.3	Бүсийн санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох	үйл ажиллагаа	Санхүүгийн тайлан	-	Аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	-Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу Үндэсний аудитын газраас	

	байгууллагуудад хүргүүлэх. Нийгмийн даатгалын шимтгэл, Хувь хүний орлогын албан татвар суутган – 1 тооцоог гаргаж тайланг баталгаажуулна.					Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын шалгалтаар “Зөрчилгүй” дүгнэгдсэн. -2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон холбогдох бусад тайланг заагдсан хугацаанд гаргаж ажилласан. -Татварын болон Нийгмийн даатгалын тайланг гаргаж холбогдох байгууллагаар баталгаажуулсан. -ХХОАТ-ын тайланг гаргаж холбогдох байгууллагын И-Такс.мн сайтад шивж илгээсэн.	100%
3.2.5	Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах	Үйл ажиллагаа	2 удаа	-Байгууллагын үндсэн хөрөнгийн 2022 оны хагас жилийн тооллого явуулах комисс байгуулагдан тооллого хийж үр дүнг “Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хурлаар хэлэлцэж бүсийн ашиглалтын хугацаа дууссан зарим тоног төхөөрөмжүүдийг дахин үнэлэх, актлах талаар өмч хамгаалах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэн холбогдох хөдөлгөөнийг санхүү бүртгэлд тусгасан.	Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавих тооллогын комисс байгуулан хагас жилээр тооллогын ажлыг зохион байгуулсан байна.	Байгууллагын Өмч хамгаалах зөвлөл нь 2023 онд хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөгөө хэлэлцэн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллав. -Байгууллагын эхний хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх комиссыг Захирагчийн Захирамжаар байгуулан бараа материалын тооллогыг хийж, хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, болон бараа материалын зардлуудын төлөвлөлтийг гаргуулж, тэдгээрийг үндэслэн төсвийн хязгаарыг нэмэгдүүлж төлөвлөх тооцоог гаргаж, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. -Төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад бүртгэлээр хяналт тавих эрх үүргийн хүрээнд	100%

						төрийн өмчит хуулийн этгээдтэй байгуулсан төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 91% үнэлгээтэй дүгнүүлсэн.	
3.2.6	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, тогтмолжуулах	Үйл ажиллагаа	-Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай эсэх; -Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргасан эсэх	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэрэг ажлууд хийгдсэн байна.	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна	-Монгол Улсын Их хурлаас тогтоож өгсөн чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн системд үл хөдлөх хөрөнгийн бүртгэлгүй, газрын мэдээллийн нэгдсэн санд газар эзэмшүүлсэн талаарх мэдээлэл ороогүй "Цагааннуур" ХК-ны нэр дээр хашаа, агуулах, гаражийн зориулалттай 8 барилга, байгууламж байна. Чөлөөт бүсийн Захирагчийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар албан бичгээр "Цагааннуур" ХК-д дээрх барилга, байгууламжийг нурааж, зөөж шилжүүлэн чөлөөт бүсийн газрыг чөлөөлөх талаар мэдэгдэл хүргүүлсэн.	100%
Зорилт-3.3. Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах							
3.3.1	Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Эдийн засаг, хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хяналтад авах, хэрэгжилтэд хяналт тавих	Үйл ажиллагаа	Албан ёсоор ирсэн шийдвэрийн тоо	"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийг бэлтгэж ЭЗХЯ-д хүргүүлсэн.	Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.	-Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Эдийн засаг, Хөгжлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад тайлагнан ажилласан. -Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023	100%

					<p>оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/16 дугаар тушаалын хавсралтаар баталсан Цагааннуур чөлөөт бүсийн инженерийн дэд бүтцийн хангамжийн зураг төсөл боловсруулах 250 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардагдах ажлын даалгаврыг боловсруулан Барилга, хот байгуулалтын яамтай зөвшилцөж, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны газарт албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Тус чөлөөт бүсийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа тамга тэмдэг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам” шинэчлэгдсэнтэй холбоотойгоор шаардлага хангахгүй болсон тул Монгол улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдаар дамжуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд албан хүсэлтээ хүргүүлсэн. Үүний дагуу Засгийн Газрын Хэрэг эрхлэх газраас хянан үзэж бүсийн Захирагчийн тамга шинэчлэн хийлгэх зөвшөөрөл олгосон. Тэмдэг шинэчлэн хийлгэх асуудлаар Чингэлтэй дүүргийн улсын</p>
--	--	--	--	--	--

						<p>бүртгэлийн хэлтсийн хяналт шалгалтын хэлтэст шаардлагатай материалыг бүрдүүлэн өгч “Хүннү” тамга тэмдгийн үйлдвэрээр дээрх тамгыг шинээр хийлгэсэн.</p> <p>-Цагааннуур чөлөөт бүсийн стратеги төлөвлөгөөг боловсруулж Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд 2023 оны А/41 дугаар тушаалаар баталсан.</p>	
3.3.2	Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж, тайлагна	Үйл ажиллагаа	төлөвлөгөө, тайлан	2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайланг хүргүүлж дүгнүүлсэн.	Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. -Төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ЭЗХЯ-д хүргүүлсэн байна. -Нэгжүүдийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг тайлагнасан байна.	Байгууллагын 2023 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. -Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг гарган, ЭЗХЯ-нд хүргүүлсэн. -Бүсийн 3 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан. -Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулсан байгууллагын албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн дарга нар баталж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан. -Албан хаагчдын тайлангийн үнэлгээг журмын дагуу үнэлгээний баг томилон ажиллуулахаар төлөвлөөд байна.	100%
3.3.3	Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах	Үйл ажиллагаа	Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо,	2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 75 албан бичиг ирсэн байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан	Албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, удирдлагын цохолтын дагуу холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байна. Байгууллагаас	Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгжүүдээс ирсэн 74 ш албан бичгийг бүртгэж, албажуулан холбогдох хэлтэс, ажилтнуудад хүлээлгэн өгч шийдвэрлэлтийн явц, хугацаанд хяналт тавин ажилласан.	



			Өргөдлийн тоо, Тайлан	мэдээг 2022 оны 11-р сарын 1-нд ЭЗХЯ-д хүргүүлсэн. - Байгууллагаас нийт 125 албан бичгийн бүрдлийг шалгаж дугаар өгч холбогдох байгууллагад хугацаа алдалгүй байгууллагын хаяг, бүртгэлийн дугаарын бичилт хийж шуудангаар болон биечлэн хүргүүлсэн.	явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийг мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.	Дээд газруудаас ирсэн бичгийн шийдвэрлэлт 100 хувь байна. Захирагчийн баталсан дүрэм журам, А захирамж 50, Б захирамж 66-ийг албажуулан холбогдох хэлтэс, ажилтанд танилцуулан ажилласан. -Ирсэн, явсан бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээг Захирагчийн ажлын албаны хуралд 7 хоног бүрд танилцуулан шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч даргад танилцуулан холбогдох хэлтэст шилжүүлэн ажиллаж байна.
3.3.4	Байгууллагын 2023 онд хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн, архивлах. Архивын баримтыг цахимжуулах	Үйл ажиллагаа	Хадгаламжийн нэгжийн тоо	Байгууллагын 2022 оны хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэсэн. Байгууллагын байнга, 70 жил хадгалах Захирагчийн захирамжийг цахимжуулав.	2023 онд хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивласан байна. Байгууллагын архивд хүлээн хадгаламжийн нэгжийг цахимжуулсан байна.	Архивын материалын хавтаслалт, хадгалалт, хамгаалалт дотоод эмх цэгцийг сайжруулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

*Төлөвлөгөөг хянасан:*

**Төсвийн Ерөнхийлөн захирагч**  
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД  
ЭДИЙН ЗАСАГ, ХӨЖЛИЙН САЙД  
(албан тушаал)

(гарын үсэг)

/Ч.ХҮРЭЛБААТАР/

(огноо)

Тэмдэг

.....

*Төлөвлөгөө тайлагнасан:*

**Төсвийн Шууд захирагч**  
ЦАГААННУУР ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
(албан тушаал)

(гарын үсэг)

/Б.НУРБЕК/

(огноо)

Тэмдэг

.....